



**“БУЛИГААР” ХК-ИЙН САНХҮҮГИЙН ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

<i>Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 2/</i>													
<i>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</i>													
Тайлагнах хугацаа	2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр												
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	“Булигаар” ХК УБГД: 9010001072, РД:2039184 MSE: MBG Утас: 99110026												
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хөрөнгийн Бирж												
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Гутлын дээд биеийн материал үйлдвэрлэх Арьс шир боловсруулалт Худалдаа Худалдааны зуучлал Гадаад худалдаа												
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	400,212,000												
Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: Ерөнхий нягтлан бодогч У.Цолмон Хянасан: Гүйцэтгэх захирал Б.Анхболд												
1. Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/													
Санхүүгийн байдлын үзүүлэлт	<table border="0"> <tr> <td>Эргэлтийн хөрөнгийн дүн:</td> <td>12,385,045,227.36</td> </tr> <tr> <td>Эгэлтийн бус хөрөнгийн дүн</td> <td>18,338,438,576.59</td> </tr> <tr> <td>Нийт хөрөнгийн дүн:</td> <td>30,723,483,803.95</td> </tr> <tr> <td>Өр төлбөрийн нийт дүн:</td> <td>19,472,136,470.17</td> </tr> <tr> <td>Эздийн өмчийн дүн:</td> <td>11,251,347,333.79</td> </tr> <tr> <td>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн:</td> <td>30,723,483,803.95</td> </tr> </table>	Эргэлтийн хөрөнгийн дүн:	12,385,045,227.36	Эгэлтийн бус хөрөнгийн дүн	18,338,438,576.59	Нийт хөрөнгийн дүн:	30,723,483,803.95	Өр төлбөрийн нийт дүн:	19,472,136,470.17	Эздийн өмчийн дүн:	11,251,347,333.79	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн:	30,723,483,803.95
Эргэлтийн хөрөнгийн дүн:	12,385,045,227.36												
Эгэлтийн бус хөрөнгийн дүн	18,338,438,576.59												
Нийт хөрөнгийн дүн:	30,723,483,803.95												
Өр төлбөрийн нийт дүн:	19,472,136,470.17												
Эздийн өмчийн дүн:	11,251,347,333.79												
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн:	30,723,483,803.95												

	Орлогын тайлан	Борлуулалтын орлого: 6,053,929,216.19 Борлуулсан бүтээгдэхүүний өртөг 4,506,753,912.48 Нийт ашиг: 1,547,175,303.71 Бусад орлого: 44,629,856.01 Борлуулалт маркетингийн зардал 99,288,981.38 Ерөнхий удирдлагын зардал 955,438,513.08 Бусад зардал: 2,732,201,658.61 Татвар төлөхийн өмнөх ашиг -2,192,306,903.18 Орлогын татварын зардал: 51,921,192.69
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	2020 оны 12 сарын 31-ны үлдэгдэл: 6,492,333,619.52 2021 оны 12 сарын 31-ны үлдэгдэл: 5,775,138,302.06 2022 оны тайлант үеийн цэвэр ашиг: 3,013,312,406.19 2022 оны 09 сарын 30-ны үлдэгдэл: 13,258,122,676.63
	Мөнгөн гүйлгээний тайлан	Мөнгөн орлогын дүн: 5,200,612,436.47 Мөнгөн зарлагын дүн: 4,309,675,521.00 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн: 890,936,915.47 Мөнгөн орлогын дүн 898,042,502.50 Мөнгөн зарлагын дүн Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн 917,718,623.40 Мөнгөн орлогын дүн 791,905,400.00 Мөнгөн зарлагын дүн: 697,776,569.41 Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр \ мөнгөн гүйлгээний дүн: 94,128,830.59 Валютын ханшийн зөрүү 12,266,737.70 Цэвэр мөнгөн гүйлгээ: 79,613,860.36 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл: 18,328,807.70 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл : 97,942,668.06
2.	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт	
	Тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн хурлаар компанийн 2022 оны 3 дугаар улирлын тайланг хэлэлцэн батлах бөгөөд 3 дугаар улирлын тайланг холбогдох журмын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, МХБ-д хүргүүлэхийг даалгасан байгаа.	
3.	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт	
3.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Санхүүгийн үзүүлэлтүүд Ашигт ажиллагаа

3.2.	<i>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт</i>	Нийт хөрөнгийн өгөөж (ROA) -7.3% Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) -20% Өөрчлөлтийн хувь /оны эхнээс/ Нийт активын өөрчлөлт 3,9% Зээлийн багцын өөрчлөлт 12% Хөрөнгөд эзлэх хувь Өөрийн хөрөнгө /Нийт хөрөнгө/ 1.8% Өр төлбөр /Нийт хөрөнгө/ 62.9% Хөрвөх чадварын харьцаа Хөрвөх чадварын хөрөнгө/ Татан төвлөрүүлсэн хөрөнгө
3.3.	<i>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл</i>	Цар тахал, хил гаалийн үйл ажиллагаа болон Украин улсад үүссэн дайны үйл явдлын нөлөөллөөс үүдэн химийн материалын үнэ өсөх, инфляци, гадаад валютын ханш өсөх, төгрөгийн ханш сулрах эрсдэлийн нөлөөлөл байна.
3.4.	<i>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох</i>	Санхүүгийн тайлангаас гадуурх бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй болно.
4.	<i>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</i>	
Тайлант хугацаанд их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдээгүй болно.		
5.	<i>Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл</i>	
Тайлант хугацаанд олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй болно.		
6.	<i>Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл</i>	
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛ		
Буигаар ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаараа Компанийн тухай хуулийн 62.1-т заасан Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах болон ТУЗ-өөс эсвэл компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэхээр тогтоосон компанийн удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагааны гол асуудлуудыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлдэг.		

Буигаар ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2022 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр 14:00 цагт ХУД-ийн 20-р хороо Арьс ширний үйлдвэрийн хашаанд байрлах компанийн өөрийн байранд зохион байгуулагдав.

Хуралд 88.1 хувийн саналын эрхтэй нийт 3 хувьцаа эзэмшигчид оролцож хурлын ирц бүрдсэнээр хурал хүчин төгөлдөр явагдсан бөгөөд хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэж, дараах хоёр асуудал дээр санал авч шийдвэр гарган батлав. Үүнд:

1. Компанийн нэмж гүйлгээнд гаргах энгийн хувьцааны тоог 140'000'000 (нэг зуун дөчин сая) хүртэлх байхаар тогтоов.
2. Компанийн “Ажиллагсад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр” (ESOP)-ийг хавсралтаар батлав.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн ээлжит хурлаар сонгогдсон ТУЗ-ийг дараах бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй бөгөөд ТУЗ нь зохих журмын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа болно. Үүнд:

Төлөөлөн Удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр:

Батчулууны Анхболд
Анхболдын Энхмэнд
Батчулууны Баянжаргал
Довжидын Гансүх
Мягмарын Төрхүү
Цэрэндагвын Мөнхлхагва

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр:

Жадамбын Эрдэнэбат
Төмөрбаатарын Болд
Чулуунбаатарын Нямдорж

ТУЗ-ийн дэргэд 3 хороо үйл ажиллагаа явуулдаг бөгөөд ТУЗ-ийн ээлжит хурал улирал тутам, хороод жилд 2 удаа ээлжит хурлаа зохион байгуулан компанийн тайлан мэдээлэлтэй танилцаж, ТУЗ-ийн зүгээс компанийн удирдлагуудад санал, зөвлөмж, үүрэг даалгавар өгч ажилладаг.

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ

Компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлж, гүйцэтгэх удирдлагын багийг удирдан ажилладаг. Тайлант хугацаанд компанийн ерөнхий нягтлан бодогч солигдсон бөгөөд гүйцэтгэх удирдлагын багийн бүрэлдэхүүн:

Гүйцэтгэх захирал Б.Анхболд
Үйлдвэрлэл хариуцсан захирал Д.Гансүх
Ерөнхий нягтлан бодогч У.Цолмон

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ КОДЕКС

“Санхүүгийн зохицуулах хороо”-ны 2022 оны 03 сарын 23-ны өдрийн №145 тоот тогтоолоор “Компанийн засаглалын кодекс” шинэчлэгдэн батлагдсан дагуу Булигаар ХК-ийн ТУЗ-ийн 2022.05.06-ны өдрийн №11/22 тоот тогтоолоор Компанийн засаглалын кодексыг хэрэгжүүлэх хөтөлбөрийг баталсан. Компанийн засаглалын кодексын хөтөлбөрийн хүрээнд тайлант жилд хийж гүйцэтгэх ажлуудыг 2022 оны ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэх ажлын төлөвлөгөөнд оруулан тус оны 2-р хагаст хийж гүйцэтгэхээр ажиллаж байна.

НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Тайлант хугацаанд нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлт гараагүй болно. Булигаар ХК нь нийт хувьцаа эзэмшигчийн тоо 2022 оны 09 дугаар сарын 02-ны байдлаар 400,212,000 хувьцааг 721 хувьцаа эзэмшигчидтэй байна. 2022 оны 03 дугаар сараас хойш хувьцаа эзэмшигчидийн тоо 38-аар нэмэгдсэн байна.

Нийт хувьцаа эзэмшигчдээс 5 ба түүнээс дээш хувийг эзэмшдэг хувьцаа эзэмшигчдэд өөрчлөлт ороогүй бөгөөд дараах нэр бүхий 3 хувьцаа эзэмшигч нь 88.11%-ийг эзэмшдэг болно. Үүнд:

Нэрс	Тоо ширхэг	Хувь
А.Энхмэнд	156,630,000	39.14%
Б.Анхболд	145,996,000	36.48%
Б.Баянжаргал	50,000,000	12.49%
Бусад 680 хувьцаа эзэмшигч	47,586,000	11.89%
Нийт дүн	400,212,000	

НОГДОЛ АШГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Компанийн ТУЗ-ийн 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 02 тоот тогтоолоо нэгж хувьцаанд 600 төгрөг хуваарилахаар шийдвэр гаргасан. Ногдол ашгийг 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тасалбар болгож “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв”-өөр дамжуулан олгохоор төлөвлөн ажиллаж байна.

БУСАД МЭДЭЭЛЭЛ

Мон-Ит Булигаар ХК нь өөрийн оноосон нэрийг “Булигаар” ХК болгон өөрчлөх, компанийн хувьцааг 1000 хуваах, Компанийн дүрмийг шинэчлэн батлах тухай шийдвэрүүдийг 2022.04.20-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан. Тус шийдвэрүүдийг Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрч, бүртгэлдээ өөрчлөлт оруулсан.

Компанийн зүгээс хувьцааг хувааснаар дараах ач холбогдолтой гэж үзэж байгаа. Үүнд:

- Нэгж хувьцааны үнэ хямд болсноор жижиг хувьцаа эзэмшигчдийн тоо нэмэгдэнэ.
- Хувьцааны арилжааны идэвх нэмэгдэж хөрвөх чадвар сайжирна.
- Арилжааны идэвх нэмэгдсэнээр хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хөрөнгө болон компанийн үнэлгээ нэмэгдэнэ.

7.	Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл
<p>Тайлант хугацаанд ТУЗ нь хороодын оруулж ирсэн саналын дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал болон санхүү бүртгэлтэй холбоотой асуудлуудаар хуралдан шийдвэр гаргасан.</p> <p>Компани нь сайн засаглалын туршлагуудаас суралцах, хэрэгжүүлэх, мэдээллийн нээлттэй ил тод байдлын зарчмыг баримтлан хувьцаа эзэмшигчдээ шаардлагатай мэдээллээр ханган, санал хүсэлт, асуултанд тухай бүр хариу өгч байгаа.</p> <p>2022.07.01-2022.09.30-ны байдлаар Цалин урамшуулал, Нэр дэвшүүлэх, Аудитын хороод тус бүр хуралдсан бөгөөд ТУЗ-ийн ээлжит хурал 2 удаа зохион байгуулан ажилласан. Тус хугацаанд нийт 8 тогтоолыг баталсан.</p> <p style="text-align: center;">МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛ</p> <p>Тайлант хугацаанд дараах тайлан мэдээллийг хуулийн хугацаанд илгээн, олон нийтэд тайлагнан ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> - 2022 оны 1-р улирал болон хагас жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг төлөвлөгөөт хугацаанд нь зохицуулагч байгууллагууд руу илгээн тайлагнасан бөгөөд улирал тутмын үйл ажиллагааны тайланг МХБ-тэй хамтран олон нийтэд танилцуулан тайлагнасан. - 2022.09.23-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зохион байгуулсан тайлан материалыг 2022.09.26-ны өдөр СЗХ, МХБ-д тус тус хүргүүлэн, хуулийн хугацаанд тайлагнасан. 	
<p>Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:</p>	
<p>Овог, нэр: Б.Анхболд Албан тушаал: “Булигаар” ХХК-ийн Гүйцэтгэх захирал</p> <p>Гарын үсэг: (Тамга/тэмдэг)</p>	<p>Овог, нэр: Албан тушаал: “_____” ХХК аудитын компанийн гүйцэтгэх захирал</p> <p>Гарын үсэг: (Тамга/тэмдэг)</p>
<p>Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:</p>	
<p>Овог, нэр: У.Цолмон Албан тушаал: Ерөнхий нягтлан бодогч</p> <p>Гарын үсэг: <i>У.Цолмон</i></p> <p>Овог, нэр: Н.Ууганцэцэг Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичиг</p> <p>Гарын үсэг: <i>Н.Ууганцэцэг</i></p>	